

Закхай

-Zacchaeus-



83Page

Тайлбарлагч Иерохо хотод нэгэн жижигхэн биетэй Закхай гэдэг нэртэй татвар хураагч амьдарч байв. Татвар хураагч гэдэг нь хүмүүсээс татвар хурааж авдаг хүнийг хэлнэ. Закхай ядуу хүнээс хүртэл хүчээр татвар хурааж авдаг байлаа. Тиймээс хүмүүс Закхайг гэмтэн гэж хочилж түүнд дургүй байв.



84Page

Тайлбарлагч Гэвч хүмүүс Закхайд дургүй болох тусам Закхай хүмүүсийг илүү зовоодог байв.

Закхай Хммм... Миний өмнө юу ч хийж чадахгүйн байж! Аргагүй л энэ дэлхий дээр мөнгө хамгийн чухал! Намайг намхан гээд доромжлоод үзээрэй! Зүгээр өнгөрөөхгүй шүү!

Тайлбарлагч Закхай өдөр бүр хүмүүсийг зовоож үүгээр бах нь ханадаг байлаа.

Закхай Татвараа өг. Алив хурдан өгөөдөх.

Хүн 1 Хэдхэн өдөр хүлээгээч. Энэ сар хүүхдүүдээ хооллох хоол ч дутмаг байна. Жоохон хугацаа өгөөч.

Закхай Тэр надад ямар хамаатайн бэ? Мөнгө байхгүй бол үр тариагаа ч болов хураалга. Өгөхгүй бол шоронд орно шүү.

Тайлбарлагч Закхай хүмүүсээс хураасан татвараар баяжив. Хүмүүс Закхайг бүр илүүгээр үзэн ядаж дургүйлхэв. Тиймээс Закхай үргэлж ганцаараа байдаг байлаа.



85Page

Тайлбарлагч Тэгтэл нэгэн өдөр Есүс Иерохо хотод ирэв. Закхай Есүс гэж ямар хүн байдаг бол гэж бодож эхлэв. Есүс олон хот тосгодоор явж өвчтэй хүнийг эдгээж Бурханы тухай зааж сургадаг тухай сонссон учраас сонирхож байлаа.

Закхай Есүс гэж ямар хүн юм бол? Нэг очиж үзье. Сонирхол татчихлаа.

Тайлбарлагч Закхай огт тээнэглзлэлгүйгээр Есүстэй уулзахаар яарав. Гэтэл аль хэдийн маш олон хүн байсан учир Есүсийн хажууд ойртож очихын арга байхгүй байв.

Закхай Явал дээрвээ? Би жоохон л өндөр байсан бол Есүсийг харж чадах байсан... Аа тийн! Ингэж болохын байна.



86Page

Тайлбарлагч Жижиг биетэй Закхайд нэгэн сайхан санаа төрөв.



87Page

Закхай Уухайс! ! Энэ инжир модны орой руу авирч гарвал Есүсийг харж чадна. Дахиад! Чү бай

Тайлбарлагч Инжир модны орой руу авирч гарвал Есүсийг харж чадахаар байлаа.

Закхай Аан... Тэр цагаан хувцастай хүн Есүс юм байна.

Тайлбарлагч Закхай Есүсийг харж байх үед, Есүс явж байснаа зогсон инжир модны зүг ширтэн харж Закхайд ингэж хэлэв.

Есүс Закхай хурдан буугаад ир. Би өнөөдөр танайд зочлох болно

Тайлбарлагч Есүс Закхайг өмнө нь таньдаг байсан хүн шиг яриу. Закхай маш баяртайгаар хурдан бууж ирэн гэртээ дагуулан ирэв.

.....

Тайлбарлагч Гэтэл олон хүмүүс энэ зүйлийг хараад хоорондоо шивэр авир хийцгээв.

Хүи2 Есүс юунд ийм гэм нүгэлтэй хүний гэрт очино вэ?

Хүи3 Харин тийн. Закхай бол маш их шуналтай, муу хүн.

Тайлбарлагч Харин Есүс үүнд анхаарлаа хандуулсангүй. Закхай бүх зүйлээрээ Есүсийг дайлав. Тэгээд тэр Есүст ингэж хэлэв.

Закхай Есүсээ би өөртөө байгаа хөрөнгөний тэн хагасыг нь ядууст хувааж өгье. Тэгээд хүмүүсээс мэхэлж авсанаа дөрөв дахин нугалж эргүүлэн төлөх болно

Есүс Закхай! Чиний бүхий л гэр бүл чинь аврагдах болно. Би энэ газарт ирсэн нь чамтай адил алдагдадсан нэгнийг аврахын тулд юм.

.....

Тайлбарлагч Закхай Есүст амласныхаа дагуу хөрөнгөнийхөө тэн хагасыг ядууст өгч хүмүүсээс мэхэлж, булааж авсанаа дөрөв дахин нугалж төлөв. Есүстэй уулзсан Закхай өөр хүн болон өөрчлөгджээ.



88Page



89Page